

**“БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ТӨСЛИЙГ ТАНИЛЦУУЛАХ БОЛОН САНАЛ АВАХ ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН
САНАЛЫГ ТУСГАСАН БАЙДАЛ**

Санал өгсөн иргэн, ААН-ийн нэр	Санал	Тайлбар
Ж.Осоржамаа /”Үнэлгээ эрхлэгчдийн холбоо” ТББ/:	<p>Зарим төрлийн ажлыг бусад төрийн бус байгууллагад хариуцуулж өгөх, оролцоо зэргийг оруулах шаардлагатай байна.</p> <p>Бусад зөвлөх үйлчилгээний салбар мэргэшсэн зөвлөхийн нуруун дээр явж байгаа.Үүнийг анхаарч Мэргэшсэн зөвлөх гэсэн заалт оруулах</p>	<p>Санал тусгаагүй. Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулах боломжтой.</p>
Сосорбарам /”Экос” ХХК/	<p>Дараах 3 асуудлыг Төрийн бус байгууллагад шилжүүлэх талаар тусгах:</p> <ol style="list-style-type: none"> 1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх асуудал 2. Тусгай зөвшөөрлийн эрхийг сунгах 3. Сургалтын үйл ажиллагаа. 	<p>Саналыг тусгаагүй. Одоогийн мөрдөж байгаа хуулинд журмаар зохицуулна гэж заасан бөгөөд тухайн заалтыг хэндөөгүй болно.</p>
Г. Бирваа /”Их засаг “ХХК/	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хянах заалтыг оруулмаар байна.	<p>Саналыг тусгаагүй. Нууцтай холбоотой асуудлын нууцын тухай хуулийг баримтлах тул энэ хуульд тусгах шаардлагагүй.</p>
	Мэдээллийн санд нууцтай холбоотой асуудлыг ямар журмаар оруулах вэ гэдгийг журмаар зохицуулах шаардлагатай байна	<p>Саналыг тусгаагүй. Нууцтай холбоотой асуудлын нууцын тухай хуулийг баримтлах тул энэ хуульд тусгах шаардлагагүй.</p>
	Хуулийн төслийн 8.4.8-д заасан иргэдийн санал, танилцуулга, тайланг хуульд ямар журмаар яаж авах вэ? гэдгийг тусгаж өгмөөр байна.	<p>Саналыг тусгасан. Хэлэлцүүлэг гэснийг хасаж “энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих баг, хорооны иргэдэд хийсэн танилцуулгын тайлан” гэж тусгасан.</p>
Б.Заяатогтох /”Эм И Си Эс Зэт Би” ХХК/	7.14.-д заасан төслийн хүчин чадал, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд гэж заасан дээр технологи гэдэг үгийг нэмж өгөх/	<p>Саналыг тусгасан. Төслийн хүчин чадал, талбайн хэмжээ, технологи өөрчлөгдсөн тохиолдолд гэж нэмж тусгасан.</p>
	14.1.3-д “Энэ хуулийн 8.4.6-д заасан төсөл уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг эхлэхэд	

	төслийн ТЭЗҮ гэдэг дээр эхний асуудалтай адил технологи гэж нэмэх	
	Мэргэшсэн зөвлөх гэсэн үгийг томьёолж хуульд оруулах.	Саналыг тусгаагүй 10.8-д заасан журмөн төсөлд тусгах боломжтой.
Д.Булганбаяр /"Жемр" ХХК/	8.4.8-д Олон нийтийн оролцоог хангах дээр хэлэлцүүлгийн тайлан гэсэн байна. Хэлэлцүүлэг хийх гэхээр ямар нэгэн байдлаар хэдэн хүн цуглуулаад дундаас нь санал гарахаар тэрийг нь базаад нэг тайлан болгоод тусгах юм шиг харагдаад байна л даа. Багийн удирдлага, сумын удирдлагуудтай хамтраад хурал хуй болгоод цуглуулдаг байсан бол одоо бүр хөдлөх амьтан олдохгүй бүр нэг чөдөр тушаа болох юм шиг санагдаж байна.	Саналыг тусгасан. Хэлэлцүүлэг гэснийг хасаж “энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих баг, хорооны иргэдэд хийсэн танилцуулгын тайлан” гэж тусгасан.
Б.Батчимэг /"Дорнын байгаль" ХХК/	8.4.8-д Жемртэй адил саналтай байна.	Саналыг тусгасан. Хэлэлцүүлэг гэснийг хасаж “энэ хуулийн 10.5-д заасны дагуу төсөл хэрэгжих баг, хорооны иргэдэд хийсэн танилцуулгын тайлан” гэж тусгасан.
Б.Майдэлгэр /"Экологийн бүтээмж" ХХК/	6.8 дээр төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон байгаль орчны мэргэжилтэй хамтраад боловсруулна гэж заасан байна. Энэ яг юу гэсэн үг вэ. Мэргэжлийн байгууллага хийдэг ажлыг төсөл хэрэгжүүлэгч өөрөө судалгаагаа хийгээд өөрөө боловсруулаад явна гэсэн үг үү. 8.4.8 дээр байгаа заалтыг би бас маш их дэмжиж байна. Иргэдийн нийтийн хурал дээр 3:1 гэдгийг заавал мөрдөхгүй гээр 3, 4 хүн хуралд ирсэн байсан ч бид төслөө танилцуулаад явах ёстой юу.	Саналыг тусгаагүй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалд тусгах боломжтой.
Б.Цэвээндарь /"Говь-Эко" ХХК/	6.8 заалт нь 6.2 дээрхтэй зөрөөд байна. Ангилал дээр төлөв байдлын тодорхойлолтын ямар төсөл дээр хийхийг ялгасан юм байна уу?	Саналыг тусгаагүй Энэ асуудал төслийн ангилал болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалын журмын төсөлд нарийвчлан тусгагдана.

	10.3-г 10.2-той нийцүүлэх	Саналыг тусгасан. 10.2 дахь заалтад нийцүүлэн “14 хүртэл хоногоор” гэж өөрчилсөн.
Б.Эрдэнээ /”Монголын байгаль орчны иргэний зөвлөл” НҮТББ/	Хуулийн төслийн 3.1.6-д байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ гэж юу гэж өгөх вэ гэдгийг тодорхойлсон байна. Энэ тодорхойлолт дотроо байгаль орчин нийгмийн нөлөөлөл гэсний дараа “Эдийн засгийн” гэж оруулах	Санал тусгаагүй Олон улсын жишгээр нийгэм дотор иргэдийн суурьшил, аюулгүй байдал, түүх, соёл, соёлын өв, дурсгалт газар, уламжлал, ёс, заншил ахуй, ахуйн нөхцөл, орлого, амьжиргаа, хөдөлмөр эрхлэх зэрэг асуудал журамд орчихсон. Үүнийг Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам, аргачлалд тодорхой тусгасан болно.
Э.Жаргалсайхан /Нийслэлийн Байгаль орчны газар/	Хуулийн төслийн 7.3-д аймаг, нийслэлийн байгаль орчны алба гэж бичих	Санал тусгасан. “... энэ хуулийн 7.7-д заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн териин захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны албаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.” гэж тусгасан.
	7.4-д шууд хэрэгжүүлэх боломжтой төсөл гэж оруулах	Зэрэглэл III ангилалд оруулсан төслийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө мэдээллийн санд бүртгээд дүгнэлтгүйг шууд хэрэгжүүлнэ гэж ойлгоно.
	Хуулийн төсөлд шинжээч гэж байна. Гэтэл орон нутагт мэргэжилтэн нь өөрөө шинжээч, албаны дарга нь бас шинжээч байдаг. Яаманд бол шинжээч, ерөнхий шинжээч гэж байдаг. Тэгхээр ахлах шинжээч гэж оруулж ирмээр байна. Ахлах шинжээч нь Байгаль орчны албаны дарга байхаар зохион байгуулах	Санал тусгаагүй. Үзэл баримтлалд дурьдаагүй заалтын оруулах боломжгүй.
	6.8-д яагаад мэргэжлийн байгууллага гэдэг нь орохгүй байгаа юм бол. байгаль орчны мэргэжилтэн батлахаар бас нэг өрөөсгөл болчих вий дээ.	
	7.2-д үйлдвэр, үйлчилгээний барилга байгууламж байхгүй юу? Газар эзэмшихийн өмнө үйлдвэр, үйлчилгээний барилга байгууламж орон сууц, барилга байгууламж гээд оруулах хамгаалалтын	Санал тусгаагүй. Төслийн ангилалаар зохицуулагдаж байгаа. Хуулийн заалтад оруулах шаардлагагүй.

	бүсэд барилгууд баригдчихаад дараа нь үнэлгээгээ нэхээд араас нь яваад байгаа байхгүй ю.	
Э.Нямдаваа /Цөмийн энергийн комисс/	14.1.3 дах заалтуудад “төлөвлөгөөгөө боловсруулна” гэснийг “боловсруулж баталгаажуулна” 3-аас доошгүй жилийн давтамжтайгаар шинэчилнэ. 5-аас доошгүй жилийн өмнө эцсийн төлөвлөгөө боловсруулж батлуулна аа гэсэн байдлаар чангатгаж хамгаалах	Санал тусгасан. 14.1.5. цацраг идэвхт ашигт малтмалын төслүүд нь уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг төсөл эхлэхээс өмнө суурь түвшинд, төсөл хэрэгжснээс хойш 5 жил тутамд, төсөл хаагдахаас 3-аас доошгүй жилийн өмнө тус тус боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх гэж оруулсан.
С.Сүхцож /Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар/	7.3 ¹ -д Бүрдүүлэх материалын хэсэгт хурлаар 14 хоног гэдгийг хасах саналтай байна. Учир нь заримдаа аж ахуйн нэгж нь материал дутуу өгдөг. мэргэжилтэн газар дээр нь үздэг хянах шатанд уддаг гэх мэт асуудлууд гардаг тул хугацаа тавьмааргүй байна.	Санал тусгаагүй. Иргэнээс Төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах тухай хуулиар баримт бичгийн бүрдэл хангаагүй бол тайлбар гаргаж сунгах эрх нь байгаа болно.
н.Зууннаст /Ашигт малтмал газрын тосны газрын Хэлтсийн дарга/	Одоогийн хэрэгжиж байгаа хуулийн 8.8 -д “Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина” гэсэн заалтаас геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэснийг хасах	Санал тусгаагүй. Энэ заалт нь нэмэлт, өөрчлөлтөд ороогүй бөгөөд одоогийн мөрдөж байгаа Ашигт малтмалын хуультай нийцэж байгаа тул өөрчлөх шаардлагагүй.
Д.Сарантуяа /"МАК" ХХК/	9.1-д байгаа “Төсөл хэрэгжүүлэгч нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаварыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн	Санал тусгасан. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг нэмж оруулсан.

	төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллагатай хамтран боловсруулж, хэрэгжүүлнэ.” гэсэн заалтаас стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах биш дээр нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг оруулах	
Л.Дүүрэнбаяр	<p>7.3¹.1.Хэрэв сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 7.3¹.1-т заасан хугацаанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээтэй холбоотой хүсэлтэд хариу хүргүүлээгүй бол тухайн төслийн талаар саналгүй гэж үзнэ.</p> <p>Төслийн 7.3-т “Хамгаалалтын захирагааны” саналыг нэмж авдаг болохоор тусгажээ. Гэвч санал авах процедур тодорхойгүйн улмаас өмнөх муу туршлага давтагдаж болзошгүй. Иймд “хамгаалалтын захирагааны саналыг ч мөн 7.3¹ -т заасан журмын дагуу авахаар тусгах” нь зүйтэй.</p>	<p>Санал тусгасан. Хуулийн төсөлд Засаг даргийн хариу өгөхтэй холбоотой заалтыг 7.11-7.13 болгож өөрчлөн найруулсан.</p> <p>Хамгаалалтын захирагааны саналын хугацааг Засаг даргын саналтай мөн адил хуулийн хугацаанд авна гэж ойлгоно.</p>
М.Батдорж	<p>1.Уламжлалт бүм газрын тос болох нүүрсний давхаргын метан хийн хайгуул , олборлолт нь Ашигт малтмалын хуулиар зохицуулагддаггүй Газрын тосны хуулиар зохицуулагддаг онцлог төсөл.</p> <p>Энэ хуулийн 7.7-д заасан журамд БО-ны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангилалаар “Газрын тос, уламжлалт бус газрын тос’, “Нүүрсний давхаргын метан хийн” хайгуул, олборлолтыг 1-р зэрэглэлд оруулсан байсан. Үүнээс Газрын тос, уламжлалт бус газрын тос, Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын шатны үйл ажиллагааг 2-р зэрэглэлрүү оруулах саналыг дэвшүүлж байна. Учир нь Газрын тос, уламжлалт бус газрын тос, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын ажил том талбайг хамардаг бөгөөд маш их геологийн геофизикийн судалгааны ажил хийгддэг бөгөөд хайгуулын шатанд БОНHY-г хийлгэх нь хайгуулын ажлыг удаашруулдаг нэг том нөхцөл болдог. Хайгуулын шатанд БОНHY-г</p>	<p>Санал тусгаагүй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалын журамд тусгах боломжтой.</p>

	<p>хийлгэх шаардлаггүй буюу 2-р зэрэглэлд байхаар нэмэлт өөрчлөлт оруулах. (Ашигт малмалын хайгуулын үе шатанд БОННҮ-г хийлгэх шаардлагагүй гэж үздэгтэй адил). харин олборлолтын үед 1-р зэрэглэл буюу БОННҮ-г хийлгэх зохицуулалттай.</p>	
	<p>2.Засгийн газартай Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй төсөл хэрэгжүүлэгч нар ямар нэгэн байдлаар орон нутгийн эсэргүүцэл бослого хөдөлгөөнтэй тулгарахад эргүүцэлийн шалтаааныг холбогдох байгууллагаар тогтоолгож хэрэв иргэдийн эсэргүүцэл бослого чухал ач холбогдолгүй, төсөл хэрэгжүүлэгчид хохирол учруулсан бол бослого хөдөлгөөн өрнүүлсэн холбогдох хүнд хариуцлага тооцдог зохицуулалттай байх.</p>	<p>Санал тусгаагүй. Зөрчлийн тухай хуулиар зохицуулагдах асуудал</p>
	<p>3.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний олон нийтийн оролцоог хангах тухай 2.8 заалтад “Хэрэв тухайн төсөл нь хэд хэдэн баг, сумын нутаг дэвсгэрийг хамарч хэрэгжих бол тухайн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хуралд тус тусад нь танилцуулж санал авна “ гэсэн байdag санал авах гэдгийг иргэд дэмжих гэж ойлгоод санал өгөхгүй хуралдаа танилцуулахгүй гэсэн асуудлыг гаргадаг бөгөөд энэ нь хайгуулын ажил хийх үйл явцыг удаашруулж төсөл хэрэгжүүлэхэд саад болдог. Энэ заалтыг төсөл хэрэгжүүлэгчид үйл ажиллагаа явуулахад хялбар байх талаас нь өөрчлөлт оруулах зэрэг саналыг дэвшүүлж байна.</p>	<p>Санал тусгаагүй. Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 8.4.8-д “энэ хуулийн 10.5-д заасны дагуу төслийн нөлөөлөлд өrtөх иргэдийн саналыг тусгасан байдал, танилцуулга;”, 10.5-д “10.5.Байгаль орчны нөлөөлийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өrtөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.” гэж заасан.</p>
	<p>5.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хайгуулын шатанд, хайгуулын ажлын төлөвлөгөөг үндэслэн баталдаг байх.</p>	
“Эко экспресс” ХХК	<p>1.7.3.1.Сум дүүргийн засаг даргын БОНЕҮ-тэй холбоотой хүсэлтийг судлах хугацааг ажлын өдөрт гэж өөрчлөх, мөн судлаад хариуг албан бичгээр гаргаж өгөх хугацааг тодорхой тусгах</p>	<p>Санал туссан. Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 7.14 заалтад туссан.</p>

	(Бидний туршлагаар хүсэлт өгсөнөөс бичиг гарах хүртэл хугацаа сараас тоологдог. Мөн татгалзсан гэдгээ амаар хэлдэг тохиодол байгаа)	
	2.7.12 Төслийн хүчин чадал, технологи, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд гэх	Санал туссан. 7.11. Төслийн хүчин чадал, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 7.10-т заасан хугацааг харгалзахгүйгээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана.” гэж оруулсан.
“Их зос” ХХК	Олон нийтийн оролцоог хангах чиглэлээр: 1. Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журамд заасны дагуу БИНХ-д тайланг хүргүүлэн 15 өдрийн дотор хурлаар хэлэлцүүлнэ гэж заасан боловч БИНХ нь байнгын бус, тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй, зарим баг, хороо 3-5 жилд нэг ч хурал хийгээгүй, ирц бүрдэхгүй байгаа зэрэг нь тухайн төслийг тодорхойгүй хугацаагаар гацааж байна. Санал: БИНХ хурлаар хэлэлцүүлэн санал өгөх хугацааг шинээр батлагдах журманд тусгаж, журамд заасан хугацаанд санал өгөөгүй тохиолдолд тодорхой саналгүйд тооцон БОНБНУ-г мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж байх	Санал тусгаагүй. Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 8.4.8-д “энэ хуулийн 10.5-д заасны дагуу төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн саналыг тусгасан байдал, танилцуулга;”, 10.5-д “10.5. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.” гэж заасанзохион байгуулна.” гэж заасан.
	2. Аливаа төслийн байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан бол холбогдох зөвшөөрөл, эрхзүйн гол бичиг баримтуудын хамгийн сүүлд хийгддэг баримт бичиг юм, Уул уурхай төслийн хувьд гэхэд хайгуулын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар авах, эрэхт хайгуул, өрөмдлөг, нөөцийн тооцоолол, нөөц улсад бүртгүүлэх, ашиглалтын тусгай зөвшөөрөл, техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны ерөнхий үнэлгээ зэрэг шат дараалсан ажлуудыг	Санал тусгаагүй Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 8.4.8-д “энэ хуулийн 10.5-д заасны дагуу төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн саналыг тусгасан байдал, танилцуулга;”, 10.5-д “10.5. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.” гэж заасан.

	<p>гүйцэтгэсний дараагаар БОНБНУ хийгдэж байна. Мөн дэд бүтэц, барилга байгууламжийн төсөл, жижиг, дунд, хүнд үйлдвэр, хөдөө аж ахуйн төслүүдэд холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөл, зураг төсөл, төслийн бэлтгэл ажил хийгдсэний дараагаар олон нийтийн саналыг авч байгаа нь хүндрэлүүд үүсгэж байна.</p> <p>БИНХ хуралдан БОНБНУ-г иргэдэд танилцуулахад тухайн төслийг эхлүүлэх, эхлүүлэхгүй асуудал дээр анхаарал хандуулан хурлын утга агуулгыг алдагдуулж, Багийн иргэдийн нийтийн хурлын саналын тогтоолыг гаргаж өгөхөөс татгалzan төслийг гацаах зогсоох асуудал уурхайн төсөл бүр дээр гарч байна.</p> <p>Санал: Аливаа төслийг эхлүүлэх зөвшөөрөл олгох болон суурь судалгааны шатанд төсөл хэрэгжүүлэгч болон иргэдийн хооронд маргаан, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийн оролцоог хангах, тусгах асуудлыг хуульд тусгах</p>	
	<p>3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг БИНХ хурлаар хэлэлцүүлэхэд ямар агуулгын хүрээнд санал авах нь тодорхойгүй байна. Жишээлбэл төслийг дэмжих, дэмжихгүй асуудал уу эсвэл байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах ажлын санал авах тухай юу гэдэг нь хууль, журманд тусгагдаагүй байна.</p> <p>Санал: Ямар агуулгын хүрээнд санал авахыг тодорхой тусгах. Тухайлбал байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах ажил, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр зэрэгт тодорхой санал авах талаар тодорхой зохицуулалт бий болгох.</p>	<p>Санал тусгаагүй Багийн иргэдийн санал заавал дэмжсэн, дэмжээгүй агуулгыг тодорхойлохгүй. Багийн иргэдээс өгсөн хүрээлэн буй орчны нөлөөллийн асуудалд өгсөн саналыг тусгана гэж ойлгоно.</p>

	<p>4.Олон нийтийн оролцоог хангахдаа төслүүдийн онцлогоос шалтгаалсан зохицуулалт байхгүй байна.</p> <p>Санал: Төслийн чиглэл, хүчин чадал, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, нийгэм эдийн засагт үзүүлэх үр өгөөж зэрэг гол үзүүлэлтүүдийг харгалзан үзэж шатлал, ангилалтайгаар олон нийтийн оролцоог хангаж, санал авах, Худалдаа, үйлчилгээ, ногоон байгууламж, цэцэрлэг хурээлэн, амралтын газар цэвэрлэх байгууламж зэрэг байгаль орчинд нөлөөлөл багатай төслүүдэд санал авах шаардлагагүй гэж үзэж байна</p>	<p>Санал тусгаагүй.</p> <p>Их ангилалд орсон төслийн хувьд нарийвчилсан үнэлгээний түвшинд олон нийтийн оролцоог төсөлд тусгана.</p>
	<p>Хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:</p> <p>1.Байгаль орчны үнэлгээний хуулийн гол зорилго нь аливаа хэрэгжиж буй төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжиж дуусахад тухайн талбайг аль болох байгалийн төрхөд дөхүүлэхэд гол зорилго нь оршиж байгаа. Иймд тус хуулийн анх батлагдсан өдрөөс өнөөдрийг хүртэл хэрэгжилтийн явцыг дүгнэж, цаашид хууль хэрэгжүүлэлтийг сайжруулах чиглэлээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Тухайбал Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд уйл ажиллагааны чиглэл онцлогт тохирсон нелеееллийг бууруулах, урьдчилан сэргийлэх олон ажил төлөвлэдэг боловч ялангуяа уул уурхай, үйлдвэрийн жижиг теслуудийн хувьд хэрэгжилт маш муу байгаа нь олон жишээнүүдээс харагдаж байна. (алтны шороон ордууд, жоншны ордууд, нуурсний жижиг ордууд, мах, арьс шир боловсруулах үйлдвэр зэрэг)</p>	<p>Санал тусгаагүй.</p> <p>Хуулийн төсөлд тусгах шаардлагагүй зохион байгуулалтын асуудал болно.</p>
	<p>2.Хуулийн хэрэгжилтийг сайжруулах үүднээс байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийг жил бүр дүгнэх, үйл ажиллагаанаас гарсан ур дунгээр урамшуулах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зэргийг хуульд тусгах</p>	<p>Санал тусгаагүй.</p> <p>Хуулийн үзэл баримтлалд тусаагүй тул хуулийн төсөлд тусгах боломжгүй болно.</p>

	<p>6.9.Төсөл хэрэгжүүлэгч нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс гарсан үр дүнгээс өөрийн үйл ажиллагаанд хамааралтай нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүний нэмэлт тодотгол болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангах үүрэг хүлээнэ.</p>	<p>Санал тусгаагүй. Стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журамд тусгах боломжтой.</p>
	<p>8.11.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10^1 зүйлд заасан байгаль орчны аудитыг хийлгэнэ.</p>	<p>Санал тусгаагүй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.2-т “....Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж заасан тул хамаарна гэж ойлгоно.</p>
“Энержи ресурс” ХХК	<p>7.9.Энэ хуулийн 7.4.3-т заасан шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны алба гаргана.</p>	<p>Санал тусгасан. Заалтын дугаар өөрчлөгдсөн. “7.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, эскиз зураг, бизнес төлөвлөгөө, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, эсхүл төлөв байдлын тодорхойлолт, тухайн хамгаалалтын захиргааны болон сум, дүүргийн Засаг даргын санал, холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн 7.7-д заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны газраар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.</p>
	<p>7.14.Техник, эдийн засгийн үндэслэлд заасан төслийн хүчин чадал, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 7.12-д заасан хугацааг харгалзахгүй нэмэлт тодотгол хийх хүсэлтийг</p>	<p>Санал тусгаагүй. Зөвхөн уул уурхайн төсөлд хамрахгүй бөгөөд нийтлэг бүх чиглэлийн төсөлд хамаарч байгаа тул хамрах хүрээг харгалзан нийтлэгээр оруулсан.</p>

	<p>төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагад гаргана.</p> <p>14 дугаар зүйл. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үүрэг</p> <p>14.1.5. иргэний хүснэгтийн дагуу өөрийн үйл ажиллагаатай холбогдлын газрын хэвллийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дунгийн талаарх мэдээлэл сөхөх, эсхүл танилцах боломжоор хангах үүрэгтэй.”</p> <p>18 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцоо</p> <p>18.7. Иргэн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвллийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах боломж олгох хүснэгтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.</p>	
	<p>6.9. Төсөл хэрэгжүүлэгч нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс гарсан үр дүнгээс өөрийн үйл ажиллагаанд хамааралтай нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүний нэмэлт төдотгол болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангах үүрэг хүлээнэ.</p>	<p>Санал тусгаагүй</p> <p>Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн иргэд олон нийтийн мэдэх эрхтэй хобоотойгоор оруулсан заалт болно.</p> <p>Санал тусгаагүй</p>
Н.Баярсайхан “Хил хязгааргүй алхам”ТББ-ын тэргүүн	<p>Хуулийн үзэл баримтлал, зорилго болон зохицуулалтыг бүхэлд нь үндсэн хууль, Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, нэн ялангуяа хүний эрхийн түгээмэл тунхаглал, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ийн тунхаглалд нийцүүлж, сүүлийн 30 жилд гарсан</p>	<p>Санал тусгаагүй.</p> <p>Хууль тогтоомжийн тухай хууль, уг хуулийг дагаж гарсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд хийгдсэн үнэлгээний дүгнэлтээр уг хуулийн төслийг шинэчлэн найруулах талаарх Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд шаардлага хангагдаагүй болно.</p>

	<p>бодлогын алдааг давтахгүй байх нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж дахин боловсруулах;</p>	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь нийт 20 зүйл 124 хэсэгтэй бөгөөд хуулийн төсөлд 10 зүйл 23 хэсэг 6 заалтыг нэмж тусган, 11 зүйл 11 хэсэг 3 заалтад өөрчлөлт оруулж анхдагч хуулийн эх бичвэрийн нийт 39,5 %-ийг хөндсөнөөр Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр 24.4-т заасны дагуу “нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулсан</p>
	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь Монгол улсын үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангахад хамгийн чухал хууль юм. Иймээс энэ хуульд шинэчилсэн найруулгын түвшний, зарчмын шинжтэй томоохон шинэчлэл хийхээр төслийг дахин боловсруулах.</p>	<p>Санал тусгаагүй. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах асуудлыг хуульчлах, Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний мэдэх эрхийг хангах төрийн үүргийн хүрээнд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу БОНБУ нь байгаль орчны мэдээллийн санд олон нийтэд нээлттэй бөгөөд иргэн хүсвэл төрийн байгууллагаас хязгаарлагдмал мэдээллийг гаргуулан авах эрхийг хуулийн төслийн 14.1.4, 14.1.5, 18.6, 18.7, 18.8 дахь заалтуудад тусгасан.</p>
	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг “байгаль орчин, нийгмийн нөлөөллийн эрсдэлийн үнэлгээний тухай хууль” болгох;</p>	<p>Санал тусгаагүй. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 1.1-р зүйлд зааснаар..... <u>бус нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино.</u> Өөрөөр хэлбэл, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 5-р зүйлээр байгаль орчны стратегийн үнэлгээ, 6-р зүйлээр хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, 7-р зүйлээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээг тус тус иж бүрэн зохицуулж байгаа бөгөөд байгаль орчны нөлөөллийн болон эрсдлийн үнэлгээ нь Байгаль</p>

		<p>орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлалд нэг асуудал болон боловсруулагддаг тул хуулийн оноосон нээршлийн хувьд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь хамгийн зөв томъёолол юм.</p>
	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд, алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын үзэл санаанд нийцүүлэн аливаа төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэхэд түүний нийгэмд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг харгалzan үзэх эрх зүйн цогц орчныг бүрдүүлэх.</p>	<p>Санал тусгасан. Одоогийн боловсруулсан хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд “төслийн ангиллын шинэчлэл, нийгмийн нөлөөлөл”-ийг авч үзэхээр тусгасан. Иймд Тогтвортой хөгжлийн зорилтууд, алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын үзэл санаанд нийцүүлэн аливаа төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэхэд түүний нийгэмд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг харгалzan үзэх эрх зүйн цогц орчныг бүрдүүлэх боломжийг энэхүү Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл нь олгож байгаа болно.</p>
	<p>Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа болон үр нөлөөний үнэлгээний тайланг (монгол улсын үндсэн хууль, монгол улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцсэн эсэх, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцсон эсэх, бусад улсын эрх зүйн зохицуулалтын судалгаа хийх) ил тод болгох;</p>	<p>Санал тусгаагүй. 1.Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн шинжилгээг хуулийн төслийг хэлэлцүүлэх явцад олон нийтэд болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд оролцогч талуудад 2 удаа танилцуулсан бөгөөд Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайланг хуулийн төслийг Засгийн газарт хэлэлцүүлж УИХ-д өргөн барих түвшинд парламент.мн сайтад иргэд олон нийтээс дахин санал авахаар байршуулахаар боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлээд байна. 2.Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулахад явцад бусад улсын Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний эрх зүйн орчны судалгааг (Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ: Олон улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний харьцуулсан судалгаа болон Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын</p>

		<p>үнэлгээ, түүний хэрэгжилт, холбогдох сайжруулах санал зөвлөмж, 2022. НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал төсөл), мөн бусад улсын төслийн ангилалын судалгааг (Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчлэлтэд зориулсан төслийн ангиллыг боловсронгуй болгох судалгаа. 2023; 5 улс, 5 олон улсын байгууллага хамруулсан, НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал төсөл), Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийхэд иргэдийн оролцоог сайжруулах нь., АМЕП төсөл, 2021 тус тус хийсэн. Эдгээр судалгааны нэгдсэн үр дүнг хуулийн төслийн хэлэлцүүлэг (МБОИЗ, төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний компани, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлүүдэд) мөн НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал төслөөс зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр (иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлүүдэд) олон нийтэд сайтар танилцуулсан болно.</p>
	<p>Нөлөөллийн үнэлгээний зардлыг төсөл хэрэгжүүлэгч өөрөө санхүүжүүлж, үнэлгээ хийлгэхдээ сөрөг дүгнэлт гаргахыг хаасан захиалга өгч, эцэст нь мөн тайланг хянан хүлээн авах эсэхээ шийддэг хоцрогдсон арга барилыг арилгах</p>	<p>Санал тусгаагүй. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т үндэслэж 7.4.3 дахь заалтаар тухайн төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийх шаардлагатайг зохицуулж байгаа. Өөрөөр хэлбэл, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.1 хэсэгт зааснаар хуулийн 7.4.3-т заасны дагуу гарсан дүгнэлтэд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын зорилт, чиглэл, хамрах хүрээ, бүрдүүлэх материал, хугацаа зэргийг заавал хийхээр тусгаж, албажуулан хүргүүлж байгаа болно. Мэргэжлийн байгууллага байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд үндэслэж байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг одоогийн хүчин төгөлдөр</p>

		үйлчилж байгаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.2-т заасан аж ахуй нэгж нь мөн хуулийн 8.4-р зүйлд заасны дагуу боловсруулдаг. Шинжээч тухайн төслийг хүлээн аваад ерөнхий үнэлгээний түвшинд өгсөн даалгаврын хүрээнд хийсэн эсэхийг хянан үзээд мэргэжлийн зөвлөлийн хуралд оруулдаг бөгөөд, мэргэжлийн зөвлөлөөс дахин хянан үзээд шаардлага хангаагүй тохиолдолд буцааж байна. Иймд төсөл хэрэгжүүлэгч нь сөрөг дүгнэлтийг гаргахыг хаах захиалга өгөх боломжгүй болно. Мөн тус хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн хүрээнд дээрх бүх зарчмууд нь хэвээрээ бөгөөд тайланг хүлээн авч хянаж холбогдох шийдвэрийг гаргах процесс олон улсад ижилхэн үйлчилдэг зарчмуудыг нэг юм.
	Уур амьсгалын нөлөөллийн эрсдэлийн үнэлгээг хийдэг болох;	Санал тусгаагүй. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журамд тусгах боломжтой. Хуулийн төсөлд оруулах шаардлагагүй.
	Байгаль орчны гэрээ конвенцоор баталгаажсан "Biodiversity habitat" тодорхойлолтод хуулийн төслийн зорилго болон үнэлгээний төрлүүдийн тодорхойлолтыг нийцүүлэх, төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн оролцоог бодитойгоор хангах тул мэдээллээр хангах, мэдлэгтэйгээр оролцох, санал шүүмжээ чөлөөтэйгөөр өгөх, хариу авах, эдгээр эрх нь зөрчигдсөн бол гомдол гаргах, үнэлгээний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг эрхийг цогцоор нь хуульчлах;	Санал тусгаагүй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн иргэдийн мэдэх эрхтэй холбоотой асуудлыг Үндсэн хуулийн 6.2 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн өөрчлөн найруулсан бөгөөд иргэдийг мэдээллээр хангах, мэдлэгтэйгээр оролцох, санал шүүмжээ чөлөөтэйгөөр өгөх, хариу авах, эдгээр эрх нь зөрчигдсөн бол гомдол гаргах, үнэлгээний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг асуудал нь Нийтийн ил тод байдлын тухай хуулиар зохицуулагдана.
	Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн хэмжээнээс хамаарч төслийн ангиллыг оновчтой	Санал тусгасан.

	<p>тогтоох шалгуур, шийдвэр гаргах үйл явцыг хуульчлах</p>	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Нөлөөллийн үнэлгээний журам, үнэлгээ хийх төслийн ангиллыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, ангилалд байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээний арга, хянан магадлагаа, олон нийтийн оролцоо, ерөнхий үнэлгээ хийх харьялал, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол, нийгмийн нөлөөллийн болон эрүүл мэндийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана.” гэж өөрчлөн найруулж 7.11, 7.12, 7.13 заалтуудыг шинээр нэмсэн.</p> <p>Ингэснээр хуулийн хавсралтад дурьдсан бүх төсөлд ижил материал шаарддаг, бусад гэсэн ангилал, чиглэл оруулснаар хуулийн хийдэл үүсч шаардлагагүй төсөлд ч үнэлгээ хийх нэхцэл бүрдэж байсныг болиулж, хуучин ангилалд байсан бусад төсөл гэснийг байхгүй болгож ангилал чиглэлийг тодорхой болгож хүрээг тогтоож өгсөн. Өөрөөр хэлбэл, олон улсын сайн жишиг болох шаталсан зармыг нэвтрүүлж өгсөн</p> <p>Тухайлбал тухайн төслийн цар хүрээ их багаас хамааруулалгүй зөвхөн химиин бодис ашигладаг л бол байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэхээр тусгагдасныг бууруулж ангилалыг шинэчилсэн.</p>
	<p>Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг зөвхөн “бүс нутаг”-ийн хэмжээнд хийхээр заасан нь оновчгүй байгааг шинэчлэн хам нөлөөллийг үнэлэх хэрэгцээ байгааг хуульчлах;</p>	<p>Санал тусгаагүй. Тодорхой бүс нутгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслийдийн хэрэгжилтийн явцад үүсэх дам болон хам нөлөөллийг төслийдийн хуримтлагдах нөлөөллийн явцад тогтоох бөгөөд түүнээс гарсан үр дүн, нөлөөллийг бууруулах арга хэмжээг төслийдийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ</p>

		<p>болон байгаль орчны менежментийн төсөлд тусгаж хэрэгжүүлэх зохицуулалтыг хуулийн төслийн 6.8, 6.9-д тусгасан. Дам болон хам нөлөөллийг хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд хэрхэн тусгах асуудлыг БОНБҮ хийх аргачлалд тодорхой тусгаж өгөхөөр зохицуулсан.</p>
	<p>Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг даалгавар буюу төсөл хэрэгжүүлэгч заавал биелүүлэх үүрэг болгосон шинжтэй болгож хуульчлах.</p>	<p>Санал тусгаагүй. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.1 дэх хэсэгт зааснаар Энэ хуулийн 7.4.3-т заасны дагуу гарсан дүгнэлтэд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын зорилт, чиглэл, хамрах хүрээ, хугацааг тодорхой заахаар тусгагдсан. Өөрөөр хэлбэл байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ нь тухай төслийг нарийвчилсан үнэлгээний түвшинд болон нөхцөл болзолтойгоор үргэлжлүүлэхэд заавал биелүүлэх ажлын даалгавар бөгөөд үүнийг байгаль орчны үнэлгээ хийх аргачлалд тодорхой зааж өгсөн.</p>
	<p>"Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ"-г тусад нь тодорхойлох. Энэ үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч жил бүр хийх ба анх тогтоосон суурь үзүүлэлт болон өмнө жилийн үзүүлэлт хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлсны үндсэн дээр дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталдаг байхаар хуульчлах.</p>	<p>Санал тусгаагүй. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.4-т "байгаль орчны төлөв байдлын үнэлгээ" гэж аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлно", Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.-д "Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах,</p>

	<p>нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна” гэж тус тус заасан.</p> <p>Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ нь тухайн төсөл хэрэгжихээс өмнөх байгаль орчны суурь судалгаа бөгөөд тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах боломжтой байхаар боловсруулагддаг тул төслийн үе шатанд төлөв байдал өөрчлөгдөж байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүссэн эсэхийг тодорхойлж чадаагүй, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг буруу тодорхойлсон бол хянан магадлагаа хийлгэж хүчингүй болгуулах, эрх бүхий албан тушаалтанд арга хэмжээ авах зохицуулалт нь одоогийн мөрдөж байгаа хуульд тодорхой заасан.</p>
	<p>Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхэд зарцуулах хугацааны доод хэмжээг хуульчлах.</p> <p>Санал тусгасан.</p> <p>Төслийн цар хүрээ, нутаг дэвсгэр, ангилал чиглэлээс шалтгаалан байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг боловсруулах хугацаа нь харилцан адилгүй бөгөөд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтээр шинжээч энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт зааснаар “Энэ хуулийн 7.4.3-т заасны дагуу гарсан дүгнэлтэд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын зорилт, чиглэл, хамрах хүрээ, хугацааг тодорхой заана” гэсний</p>

		<p>дагуу нарийвчилсан үнэлгээг боловсруулж ирүүлэх хамгийн боломжит хэмжээг тусгаж өгч байна. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас тухай төслийн үйл ажиллагаанд санал өгөх, хянах хугацааг тодорхой болгож хуулийн төсөлд тусгасан.</p>
	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг заавал тухайн төслийн техник-эдийн засгийн үндэслэл батлагдсаны дараа хийх зэрэг зарчмын шинэлэг зохицуулалтыг шинэчилсэн найруулгаар бий болгох шаардлагатай.</p>	<p>Санал тусгаагүй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, эскиз зураг, бизнес төлөвлөгөө, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, эсхүл төлөв байдлын тодорхойлолт, тухайн хамгаалалтын захиргааны болон сум, дүүргийн Засаг даргын санал, холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн 7.7-д заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.” гэж заасан бөгөөд одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуулиар ч нарийвчилсан үнэлгээний түвшинд ТЭЗҮ-г батлагдсаны дараа БОНБ-ын нарийвчилсан үнэлгээг хянаж мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байна.</p>

--- 000 ---